



IAF Mandatory Document

ОУИФ Заавал мөрдөх баримт бичиг

**ISO/IEC 27001:2022 СТАНДАРТЫН
ШИЛЖИЛТИЙН ШААРДЛАГА
TRANSITION REQUIREMENTS
FOR ISO/IEC 27001:2022**

Хэвлэл 2

(IAF MD 26:2023)

Хэвлэсэн огноо: 15.02.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 15.02.2023

Олон Улсын Итгэмжлэлийн Форум (ОУИФ) нь ОУИФ-ын гишүүнээр итгэмжлэгдсэн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын гаргасан үр дүнг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, Итгэмжлэлийн байгууллага (ИБ)-уудын дунд дэлхий хэмжээний харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэгч болон зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн худалдааг хөнгөвчилдөг.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд итгэмжлэлийн хамрах хүрээнд багтсан ажлаа гүйцэтгэх чадамжтайг батлах замаар бизнес болон тэдгээрийн хэрэглэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг. ОУИФ-ын гишүүн ИБ болон тэдгээрийн итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь олон улсын стандарт, тэдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулсан ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг мөрдөх шаардлагатай.

ОУИФ-ын Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн ИБ-уудын итгэмжлэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд итгэлийг бий болгохын тулд ижил түвшний багаас бүрдсэн үнэлгээг тогтмол явуулдаг. ОУИФ-ын ХХЗХ-ийн бүтцийн талаар ОУИФ-ын бодлогын баримт бичиг 3 (IAF PL 3) “ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний бүтэц ба ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний өргөтгөлийн бодлого, журам”-д дэлгэрэнгүй тусгасан. Мөн ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний талаар ОУИФ-ын ХХЗХ-ийн статус баримт бичигт тусгасан.

ОУИФ-ын ХХЗХ-ийн нь дараах таван түвшний бүтэцтэй. Үүнд:

1-р түвшин нь ISO/IEC 17011 стандартыг хэрэгжүүлэгч бүх ИБ-уудад хамаарах заавал мөрдөх шалгуурыг тодорхойлно. 2-р түвшний үйл ажиллагаа болон холбогдох 3-р түвшний норматив баримт бичиг(үүд)-ийн нэгдлийг ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээ гэж нэрлэдэг.

The International Accreditation Forum, Inc. (IAF) facilitates trade and supports industry and regulators by operating a worldwide mutual recognition arrangement among Accreditation Bodies (ABs) in order that the results issued by Conformity Assessment Bodies (CABs) accredited by IAF members can be accepted globally.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited CABs are competent to carry out the work they undertake within their scope of accreditation. ABs that are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

ABs that are signatories to the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) are evaluated regularly by an appointed team of peers to provide confidence in the operation of their accreditation programs. The structure of the IAF MLA is detailed in IAF PL 3 - Policies and Procedures on the IAF MLA Structure and for Expansion of the Scope of the IAF MLA. The scope of the IAF MLA is detailed in the IAF MLA Status document.

The IAF MLA is structured in five levels:

Level 1 specifies mandatory criteria that apply to all ABs, ISO/IEC 17011. The combination of a Level 2 activity(ies) and the corresponding Level 3 normative document(s) is called the main scope of the MLA, and the combination of Level 4 (if

4-р түвшин (хэрэв байгаа бол) болон 5-р түвшний холбогдох норматив баримт бичгийн нэгдлийг ХХЗХ-ийн дэд хамрах хүрээ гэж нэрлэдэг.

- ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалт гэх мэт үйл ажиллагаа болон ISO/IEC 17065 зэрэг холбогдох заавал мөрдөх стандарт багтана. Үндсэн хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил найдвартай гэж үзнэ.
- ХХЗХ-ийн дэд хүрээнд тохирлын үнэлгээний шаардлагууд буюу ISO 9001 болон схемийн тусгай шаардлага, тухайлбал ISO 22003-1 стандартууд багтана. Дэд хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил тэнцүү гэж үзнэ.

ОУИФ-ын ХХЗХ нь тохирлын үнэлгээний үр дүнг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг төрүүлдэг. ОУИФ-ын ХХЗХ-т гарын үсэг зурсан ИБ-аар итгэмжлэгдсэн байгууллагын ОУИФ-ын ХХЗХ-ийн хүрээнд гаргасан баталгааг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, улмаар олон улсын худалдааг хөнгөвчилнө.

Хэвлэл 2

Боловсруулсан: ОУИФ-ын Техникийн хороо

Баталсан: ОУИФ-ын гишүүд

Огноо: 03.02.2023

Хэвлэсэн огноо: 15.02.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 15.02.2023

Холбоо барих: Элва Нилсен

ОУИФ Нарийн бичгийн дарга

Утас: +1 613 454-8159

И-мейл: secretary@iaf.nu

applicable) and Level 5 relevant normative documents is called a sub-scope of the MLA.

- The main scope of the MLA includes activities e.g. product certification and associated mandated standards e.g. ISO/IEC 17065. The attestations made by CABs at the main scope level are considered to be equally reliable.
- The sub scope of the MLA includes conformity assessment requirements e.g. ISO 9001 and scheme specific requirements, where applicable, e.g. ISO 22003-1. The attestations made by CABs at the sub scope level are considered to be equivalent.

The IAF MLA delivers the confidence needed for market acceptance of conformity assessment outcomes. An attestation issued, within the scope of the IAF MLA, by a body that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide, thereby facilitating international trade.

Issue 2

Prepared by: IAF Technical Committee

Approved by: IAF Members

Date: 03 February 2023

Issue Date: 15 February 2023

Application Date: 15 February 2023

Name for Enquiries: Elva Nilsen

IAF Corporate Secretary

Contact Phone: +1 (613) 454 8159

Email: secretary@iaf.nu

АГУУЛГА

1. УДИРТГАЛ
2. ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ
 - 2.1 ОРШИЛ
 - 2.2 ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД
 - 2.3 НӨЛӨӨЛӨЛ
3. ТҮЛХҮҮР ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭ
4. ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ҮЙЛ
ЯВЦЫН АРГА ХЭМЖЭЭ
 - 4.1 ИБ-ЫН АВАХ АРГА ХЭМЖЭЭ
 - 4.2 ТҮБ-ЫН АВАХ АРГА ХЭМЖЭЭ
 - 4.3 БУСАД

TABLE OF CONTENTS

1. INTRODUCTION
2. SUMMARY OF CHANGES
 - 2.1 BACKGROUND
 - 2.2 KEY CHANGES
 - 2.3 THE IMPACT
3. KEY TIMESCALE
4. TRANSITION PROCESS ACTIONS
 - 4.1 AB ACTIONS
 - 4.2 CAB ACTIONS
 - 4.3 OTHER

ОУИФ-ЫН ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байвал зохино” нэр томъёо нь шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллагад (ИБ) нотлон харуулсан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байх ёстой” нэр томъёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

INTRODUCTION TO IAF MANDATORY DOCUMENTS

The term “should” is used in this document to indicate recognised means of meeting the requirements of the standard. A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term “shall” is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

ISO/IEC 27001:2022 СТАНДАРТЫН ШИЛЖИЛТИЙН ШААРДЛАГА

1. УДИРТГАЛ

Норматив баримт бичгийн шилжилтийн тухай мэдээллийг олгох бүх баримт бичгүүд нь энэхүү баримт бичигт нарийвчлан тусгасан хамрах хүрээнд ОУИФ-ын ХХЗХ-ийн гишүүн ИБ болон итгэмжлэгдсэн ТҮБ-уудын зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг болно. Энэхүү баримт бичгийг IAF PR 7:2022 “Шилжилтийн үед ОУИФ-ын заавал мөрдөх баримт бичгийг боловсруулах шаардлага”-ын дагуу ОУИФ-ын техникийн хорооноос томилогдсон ажлын хэсэг боловсруулсан болно.

Энэхүү баримт бичиг нь дараах шилжилтийн шаардлагуудыг тусгасан бөгөөд ОУИФ-ын ХХЗХ-ийн гишүүн ИБ болон итгэмжлэгдсэн ТҮБ-ууд заавал мөрдөнө.

TRANSITION REQUIREMENTS FOR ISO/IEC 27001:2022

1. INTRODUCTION

All documents that provide information on transitions of normative documents will be mandatory documents to be followed by IAF MLA Accreditation Bodies (AB) signatories and accredited Conformity Assessment Bodies (CABs), with the scope as detailed in this document. This document is developed by an appointed Task Force of the IAF Technical Committee and in accordance with IAF PR 7:2022 *Requirements for Producing IAF Mandatory Documents on Transitions*.

This document provides transition requirements for the following and is mandatory for the related IAF MLA AB signatories and accredited CABs.

Норматив баримт бичиг/Normative Document:	ISO/IEC 27001:2022
Орлож буй/Replacing:	ISO/IEC 27001:2013
Одоогийн статус (ЗМББ хэвлэл) /Current Status (at the time of MD publication)	IS
Шилжилтийн хугацаа/Transition Period:	3 жил (36 сар) / 3 years (36 months)

2. ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2.1 Оршил

ОУСБ-ын холбогдох бодлогын дагуу ISO/IEC FDIS* 27001:2022 нь ISO/IEC 27001:2013 стандартыг ISO/IEC 27001:2013/COR1:2014, ISO/IEC 27001:2013/COR2:2015 and ISO/IEC 27001:2013/DAmD1 стандарттай нэгтгэх замаар 2022 оны 7-р сард боловсруулагдсан. Мөн ОУСБ-аас ISO/IEC FDIS* 27001:2022-ыг 2022 оны ISO/IEC Удирдамж, 1-р хэсэг, нэгтгэсэн ОУСБ-ын нэмэлтийн SL хавсралтын дагуу Менежментийн тогтолцооны стандарт (MTC)-уудтай уялдсан бүтэцтэй болгосон. FDIS-ийн санал хураалтын үр дүнгийн дагуу ОУСБ-аас 2022 оны 10-р сарын 25-нд ISO/IEC 27001:2022 стандартыг нийтэлсэн.

**Final draft of international standard-Олон улсын стандартын сүүлийн төсөл*

Тайлбар 1: ISO/IEC 27001:2013/DAmD1-ыг ISO/IEC 27002:2022 стандарттай уялдуулан боловсруулсан бөгөөд А хавсралт болон 6.1.3 с) заалтын тайлбаруудыг шинэчилсэн. DAmD нь нэмэлт өөрчлөлтийн төслийн товчлол юм.

Тайлбар 2: Одоогийн олон улсын стандартыг тодотгох нэмэлт баримт бичгийг хоёроос илүүгүйгээр нийтлэх (2022 оны ISO/IEC Удирдамжийн 1-р хэсэг, 2.10.3-ыг үзнэ үү) тул ISO/IEC 27001-ийн шинэ хэвлэлийг ISO/IEC 27001:2013/ DAmD1-ийг бэлтгэсний дараа нийтлэх шаардлагатай болсон.

2.2 Гол өөрчлөлтүүд

ISO/IEC 27001:2013 стандарттай харьцуулахад ISO/IEC 27001:2022 стандартын үндсэн өөрчлөлтүүдээс дурдвал:

- 1) А хавсралтад хяналтын нэр, хяналтын мэдээллийг оруулж, ISO/IEC 27002:2022 стандартын мэдээллийн аюулгүй байдлын хяналтуудыг эш татсан.
- 2) Clause 6.1.3 с) заалтын тайлбаруудад хяналтын зорилтуудыг устгах, “хяналт” гэснийг “мэдээллийн аюулгүй байдлын хяналт” гэж орлуулах зэргээр хянаж, шинэчилсэн.

2. SUMMARY OF CHANGES

2.1 Background

According to the related ISO policy, ISO/IEC FDIS 27001:2022 was prepared through integrating ISO/IEC 27001:2013 with ISO/IEC 27001:2013/COR1:2014, ISO/IEC 27001:2013/COR 2:2015 and ISO/IEC 27001:2013/DAmD1 in July 2022. Additionally, ISO required ISO/IEC FDIS 27001:2022 to align with the harmonized structure for management system standards (MSS) defined in Annex SL of the ISO/IEC Directives, Part 1, Consolidated ISO supplement, 2022. Based on the result of the FDIS ballot, ISO published ISO/IEC 27001:2022 on 25 October 2022.

Note 1: ISO/IEC 27001:2013/DAmD1 was prepared to align with ISO/IEC 27002:2022, which updated Annex A and the notes of Clause 6.1.3 c). DAmD is the abbreviation of Draft Amendment.

Note 2: No more than two separate documents in the form of amendments shall be published modifying a current International Standard (see ISO/IEC Directive Part 1, 2022, Clause 2.10.3), therefore, the new edition of ISO/IEC 27001 had to be published after the preparation of ISO/IEC 27001:2013/DAmD1.

2.2 Key Changes

Compared with ISO/IEC 27001:2013, the main changes of ISO/IEC 27001:2022 include, but are not limited to:

- 1) Annex A references the information security controls in ISO/IEC 27002:2022, which includes the information of control title and control.
- 2) The notes of Clause 6.1.3 c) are revised editorially, including deleting the control objectives and using “information security control” to replace “control”.

- 3) 6.1.3 d) заалтын үг хэллэгийг болзошгүй ойлгомжгүй байдлыг арилгах үүднээс өөрчлөн найруулсан.
 - 4) 4.2 c) заалтыг мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (МАБМТ)-р дамжуулан сонирхогч талуудын шаардлагыг тодорхойлох зорилгоор нэмсэн.
 - 5) МАБМТ-ны өөрчлөлтийг байгууллага төлөвлөгөөт байдлаар тодорхойлох, өөрчлөлтийг төлөвлөх гэсэн 6.3 дэд заалтыг нэмсэн.
 - 6) Баримтжуулсан мэдээлэлтэй холбоотой үйл үгийн уялдаа холбоог гаргасан, тухайлбал 9.1, 9.2.2, 9.3.3 болон 10.2 заалтад тусгагдсан “XXX-ын нотолгоо бүхий баримтжуулсан мэдээлэл байна”
 - 7) 8.1 дэх заалтаас “гаднаас гүйцэтгүүлсэн үйл явц” гэснийг “гаднаас хангасан үйл явц, бүтээгдэхүүн, үйлчилгээ” гэснээр орлуулж, “гаднаас гүйцэтгүүлэх” нэршлийг хассан.
 - 8) 9.2 Дотоод аудит, 9.3 Менежментийн дүн шинжилгээ дэд заалтуудын нэр болон дарааллыг өөрчилсөн.
 - 9) 10 Сайжруулалт заалтын хоёр дэд заалтын дарааллыг сольсон.
 - 10) Ном зүйд тусгагдсан ISO/IEC 27002, ISO 31000 стандарт зэрэг баримт бичгүүдийг шинэ хувилбараар нь шинэчилсэн.
 - 11) МТС-тай уялдуулсан бүтэцтэй нийцүүлэх үүднээс ISO/IEC 27001:2013 стандартын зарим заалтыг өндөр түвшний бүтэц, үндсэн ижил текст, нийтлэг нэр томъёо, МТС-ын үндсэн тодорхойлолт болгон шинэчилсэн болно, жишээлбэл, 6.2 d) заалт.
- 3) The wording of Clause 6.1.3 d) is re-organized to remove potential ambiguity.
 - 4) Adding a new item 4.2 c) to determine the requirements of the interested parties addressed through an information security management system (ISMS).
 - 5) Adding a new subclause 6.3 - Planning for changes, which defines that the changes to the ISMS shall be carried out by the organization in a planned manner.
 - 6) Keeping the consistency in the verb used in connection with documented information, for example, using “Documented information shall be available as evidence of XXX” in clauses 9.1, 9.2.2, 9.3.3 and 10.2.
 - 7) Using “externally provided process, products or services” to replace “outsourced processes” in Clause 8.1 and deleting the term “outsource”.
 - 8) Naming and reordering the subclauses in Clause 9.2 - Internal audit and 9.3 - Management review.
 - 9) Exchanging the order of the two subclauses in Clause 10 - Improvement.
 - 10) Updating the edition of the related documents listed in Bibliography, such as ISO/IEC 27002 and ISO 31000.
 - 11) Some deviations in ISO/IEC 27001:2013 to the high-level structure, identical core text, common terms and core definitions of MSS are revised for consistency with the harmonized structure for MSS, for example, Clause 6.2 d).

Тайлбар 1: ISO/IEC 27001:2013/Damd1-ын эхний хоёр зүйл, ISO/IEC 27001:2013/COR 2:2015-ын гурав дахь зүйл, бусад өөрчлөлтүүд нь МТС-ын уялдуулсан бүтцээс үүдэлтэй.

Тайлбар 2: Хуучин хувилбартай харьцуулахад мэдээллийн аюулгүй байдлын хяналтын тоо нь ISO/IEC 27002:2022 стандартын 14-т заасан 114 хяналтаас 4-т заасан 93 хяналт хүртэл буурсан.

Note 1: The first two items come from ISO/IEC 27001:2013/DAmD1, the third item is from ISO/IEC 27001:2013/COR 2:2015 and the other changes result from the harmonized structure for MSS.

Note 2: Compared with the old edition, the number of information security controls in ISO/IEC 27002:2022 decreases from 114 controls in 14 clauses to 93 controls in 4 clauses. For the controls

ISO/IEC 27002:2022 стандартын хяналтуудын хувьд 11 хяналт шинээр нэмэгдэж, 24 хяналтыг одоогийн хяналттай нэгтгэж, 58 хяналт шинэчлэгдсэн. Мөн хяналт бүрт “шинж чанар”, “зорилго”-ыг оруулж, хяналтын бүлэгт “зорилт” гэснийг ашиглахаа больж хяналтын бүтцийг шинэчилсэн.

Тайлбар 3: ISO/IEC 27001:2013/COR 1:2014 нь А хавсралттай холбоотой бөгөөд ISO/IEC 27001:2013/DAMd1-тай давхцана.

2.3 Нөлөөлөл

ISO/IEC 27001:2022 стандартын өөрчлөлтийн нөлөөлөлд шинээр оруулсан А хавсралт болон 6.3 Өөрчлөлтийн төлөвлөлт заалтууд орох ч үүгээр хязгаарлагдахгүй. Учир нь:

- 1) ISO/IEC 27001:2013/COR 2:2015 стандарт нь хэдийнээ нийтлэгдэж, хэрэгжиж буй,
- 2) А хавсралт нь норматив шинжтэй,
- 3) МТС-тай уялдуулсан бүтэц нь өндөр түвшний бүтэц, үндсэн ижил текст, нийтлэг нэр томъёо, МТС-ын үндсэн тодорхойлолтуудад зориулсан жижиг засвар бөгөөд ихэнх өөрчлөлтүүдийг хяналтын шинжтэй гэж үздэг.

А хавсралтад заасан хяналтын багц лавлагааг ашигладаг ISO/IEC 27001 стандартын шаардлагууд нь байгууллагаас тодорхойлсон мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг А хавсралт (6.1.3 c)) болон Хэрэглэх тухай мэдэгдэл (6.1.3 d)-д заасантай харьцуулах үйл явц юм. (6.1.3 d)). Байгууллага нь шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг А хавсралттай харьцуулсанаар ISO/IEC 27001:2022 стандартын А хавсралтаас шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг санамсаргүй орхигдуулаагүй гэдгээ баталж болно.

Ийм харьцуулалт нь санамсаргүйгээр орхигдсон шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг илрүүлэхэд хүргэж болохгүй. Гэсэн хэдий ч шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг санамсаргүйгээр орхигдуулсан

in ISO/IEC 27002:2022, 11 controls are new, 24 controls are merged from the existing controls, and 58 controls are updated. Moreover, the control structure is revised, which introduces “attribute” and “purpose” for each control and no longer uses “objective” for a group of controls.

Note 3: ISO/IEC 27001:2013/COR 1:2014 is related to Annex A and overlapped by ISO/IEC 27001:2013/DAMD1.

2.3 The Impact

The impact of the changes in ISO/IEC 27001:2022 includes, but is not limited to the introduction of a new Annex A and Clause 6.3 - Planning for changes because:

- 1) ISO/IEC 27001:2013/COR 2:2015 has already been published and implemented.
- 2) Annex A is normative.
- 3) The harmonized structure for MSS is considered as a minor revision for the high-level structure, identical core text, common terms and core definitions of MSS, in which most of the changes are considered editorial.

The requirements in ISO/IEC 27001 that use the reference control set in Annex A are the comparison process between the information security controls determined by the organization and those in Annex A (6.1.3 c)) and the production of a Statement of Applicability (6.1.3 d)). By comparing the necessary information security controls to those in Annex A, the organization may confirm that any necessary information security control from the reference set in Annex A of ISO/IEC 27001:2022 is not inadvertently omitted.

Such comparison might not lead to the discovery of any necessary information security control that has been inadvertently omitted. However, if inadvertently omitted necessary information security controls are discovered, the organization shall update its risk treatment plans

тохиолдолд байгууллага нь шаардлагатай мэдээллийн аюулгүй байдлын нэмэлт хяналтыг бий болгохын тулд эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө шинэчилж, хэрэгжүүлнэ.

Дээр дурдсанчлан ISO/IEC 27001:2022 стандартын МАБМТ-г хэрэгжүүлсэн байгууллагуудад үзүүлэх нөлөөлөл нь тийм ч чухал байх албагүй.

to accommodate the additional necessary information security controls and implement them.

As implied above, the impact of ISO/IEC 27001:2022 on the organizations that have implemented ISMS need not be significant.

3. ТҮЛХҮҮР ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭ

3. KEY TIMESCALE

Үйл ажиллагаа/Activity	Дуусах огноо/Due Date
ИБ/AB	
ИБ нь дараах хугацаанаас хэтрүүлэхгүй ISO/IEC 27001:2022 стандартын дагуу үнэлгээ хийхэд бэлэн болно. <i>AB to be ready to assess to ISO/IEC 27001:2022 no later than</i>	ISO/IEC 27001:2022 стандарт нийтлэгдсэн сарын сүүлийн өдрөөс хойш 6 сар (энэ нь 2023 оны 4-р сарын 30-ны өдөр) <i>6 months from the last day of publication month of ISO/IEC 27001:2022 (i.e. 30 April 2023)</i>
ИБ нь дараах хугацаанаас хэтрэхгүй бүх анхдагч итгэмжлэлийн үнэлгээнд ISO/IEC 27001:2022 стандартыг хэрэглэнэ. <i>Initial assessment by AB to ISO/IEC 27001:2022 only, to begin no later than</i>	ISO/IEC 27001:2022 стандарт нийтлэгдсэн сарын сүүлийн өдрөөс хойш 6 сар (энэ нь 2023 оны 4-р сарын 30-ны өдөр) <i>6 months from the last day of publication month of ISO/IEC 27001:2022 (i.e. 30 April 2023)</i>
ИБ-ын бүх ТҮБ-ууд шилжиж дууссан байна. <i>AB transition of CABs completed by</i>	ISO/IEC 27001:2022 стандарт нийтлэгдсэн сарын сүүлийн өдрөөс хойш 12 сар (энэ нь 2023 оны 10-р сарын 31-ний өдөр) <i>12 months from the last day of publication month of ISO/IEC 27001:2022 (i.e. 31 October 2023)</i>
ТҮБ/CAB	
ТҮБ нь дараах хугацаанаас хэтрэхгүй ISO/IEC 27001:2022 стандартын дагуу анхдагч болон давтан баталгаажуулалтыг хийнэ. <i>Initial certification and recertification by CAB to ISO/IEC 27001:2022 only, to begin no later than</i>	ISO/IEC 27001:2022 стандарт нийтлэгдсэн сарын сүүлийн өдрөөс хойш 18 сар (энэ нь 2024 оны 4-р сарын 30-ны өдөр) <i>18 months from the last day of publication month of ISO/IEC 27001:2022 (i.e. 30 April 2024)</i>
ТҮБ-ын бүх баталгаажсан үйлчүүлэгчид шилжиж дууссан байна. <i>CAB transitions of certified clients completed by</i>	ISO/IEC 27001:2022 стандарт нийтлэгдсэн сарын сүүлийн өдрөөс хойш 36 сар (энэ нь 2025 оны 10-р сарын 31-ний өдөр) <i>36 months from the last day of publication month of ISO/IEC 27001:2022 (i.e. 31 October 2025)</i>

**4. ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ҮЙЛ
ЯВЦЫН АРГА ХЭМЖЭЭ**

4. TRANSITION PROCESS ACTIONS

4.1 ИБ-ын авах арга хэмжээ

4.1 AB Actions

<i>Үйл ажиллагаа /Activity</i>	<i>T/Y Y/N</i>	<i>Тэмдэглэл</i>	<i>Notes</i>
ИБ-ын зохицуулалт/ <i>AB's Arrangements</i>	<i>Тийм/ Yes</i>	<p>1) ИБ нь энэхүү баримт бичгийн шаардлагын дагуу ISO/IEC 27001:2022 стандартын шилжилтийн зохицуулалтыг бий болгоно.</p> <p>2) Шилжилтийн зохицуулалт нь ИБ болон ТҮБ-ын юу хийх талаар тусгасан байна. ИБ нь шилжилтийн зохицуулалтын хэд хэдэн баримт бичигтэй байж болно.</p> <p>3) Шилжилтийн зохицуулалт нь дор хаяж дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ISO/IEC 27001 стандартын өөрчлөлт, зөрүүний шинжилгээ • ISO/IEC 27001:2022 стандартын чадамжтай холбогдох ажилтан, шилжилтийн үйл явц <p>Тайлбар: Итгэмжлэлийн үнэлгээний баг нь бүхэлдээ мэдээллийн аюулгүй байдлын технологи, практикийн талаар мэдлэгтэй байна. (IAF MD 13:2020, 4.2-ыг үзнэ үү). Бидний мэдэж байгаачлан ISO/IEC 27002 стандарт нь мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх арга зүйн зааврыг багтаасан ерөнхий багц лавлагааг агуулдаг.</p> <ul style="list-style-type: none"> • ISO/IEC 27001 стандартын өөрчлөлтийн дагуу өөрчлөлт орох ИБ-ын үйл явц, баримт бичиг, мөн итгэмжлэлийн үйл ажиллагааг удирдах мэдээлэл технологийн системүүдийг тодорхойлно. • Шилжилтийн үеийн үнэлгээний хөтөлбөр • Шилжилтийн үеийн үнэлгээний хөтөлбөр, тухайлбал цаг хугацаа, шилжилтийн үнэлгээний арга 	<p>1) AB shall establish its transition arrangement for ISO/IEC 27001:2022 considering the requirements of this document.</p> <p>2) The transition arrangement shall address what the AB shall do and what the CABs shall do. The AB may have several separate documents to address the transition arrangement.</p> <p>3) The transition arrangement shall include at least the consideration of the following:</p> <ul style="list-style-type: none"> • The changes in ISO/IEC 27001 and the gap analysis. • The relevant personnel are competent for ISO/IEC 27001:2022 and transition process. <p>Note: The assessment team, as a whole, shall have knowledge of information security technologies and practices (see IAF MD 13:2020, 4.2). As we all know, ISO/IEC 27002 provides a reference set of generic information security controls including implementation guidance.</p> <ul style="list-style-type: none"> • The AB's related processes and documents affected by the change in ISO/IEC 27001 are identified, as well as IT systems for managing accreditation activities, if applicable. • The transition assessment programme. • There is a timely communication to CABs on

		<p>барил, ТҮБ шилжилтийг заасан хугацаанд дуусгагүйгээс гарах үр дагавар зэрэг шилжилтийн үнэлгээний хөтөлбөрийн талаар ТҮБ-тай цаг тухайд нь харилцах харилцаа холбоо</p> <p>4) ИБ-ууд шаардлагатай арга хэмжээг боломжит хамгийн эрт байдлаар төлөвлөж, эхлүүлэх нь зүйтэй.</p>	<p>the transition assessment programme, such as the timeline and transition assessment approach, and the consequences for not completing the transition by the deadline.</p> <p>4) ABs are encouraged to plan and commence required actions at the earliest opportunity.</p>
ТҮБ-ын баримт бичгийн хяналт/ <i>CAB Document Review</i>	<i>Үгүй/ No</i>		
ТҮБ-ын техникийн баримт бичгийн хяналт/ <i>CAB Technical Document Review</i>	<i>Тийм/ Yes</i>	<p>1) ИБ-аас ТҮБ нь ISO/IEC 27001:2022 стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд техникийн баримт бичгийн үзлэгийг хийнэ.</p> <p>2) ИБ нь ТҮБ-ын шилжилтийн зохицуулалт нь тохиромжтой эсэхийг тодорхойлно, ингэхдээ ТҮБ-аас ирүүлсэн дараах мэдээллүүдийг хянан үзэх замаар хэрэгжүүлэлтийн үр нөлөөг авч үзнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ISO/IEC 27001:2022 стандартын өөрчлөлтийн зөрүүний шинжилгээ, • Шилжилтийн зохицуулалт болон хэрэгжүүлэлтийн баримт нотолгоо, • Холбогдох ажилтны зөвшөөрөл, • ИБ-аас шаардлагатай гэж үзсэн бусад холбогдох мэдээлэл. 	<p>1) AB shall conduct the technical document review to confirm whether or not CABs are competent for ISO/IEC 27001:2022.</p> <p>2) AB shall determine the suitability of the CAB's transition arrangement and, if applicable, the effectiveness of its implementation through reviewing the following information submitted by CABs:</p> <ul style="list-style-type: none"> • The gap analysis of the changes in ISO/IEC 27001:2022. • The transition arrangement and its implementation evidence. • The authorization of the related personnel. • The other relevant information deemed necessary by AB.
ТҮБ-ын төв оффис дахь техникийн үнэлгээ/ <i>Technical Assessment at CAB Head Office (on-site or remote) Review</i>	<i>Хэрэв боломжтой бол/ If applicable</i>	Хэрэв ИБ нь ТҮБ-ын техникийн баримт бичгийн үзлэгээр хангалттай баримт нотолгоо авах боломжтой бол ТҮБ-ын төв оффис үнэлгээ шаардлагагүй. Хэрэв ИБ нь ТҮБ-ын шилжилтийн зохицуулалтын үр дүнтэй хэрэгжүүлэлт, нийцлийг баталгаажуулах боломжгүй бол оффис үнэлгээ шаардлагатай.	If AB is able to obtain sufficient evidence through the CAB technical document review, then a CAB head office assessment is not required. If AB is not able to verify the effective implementation and conformance with the CAB's transition arrangement, then an office assessment is required.
ТҮБ-ын гэрчлэх	<i>Үгүй/</i>		

үнэлгээ/ CAB Witnessed Assessment(s)	No		
Шилжилтийн үед нэмэлт хугацаа хэрэгтэй юу? / Is extra time likely to be needed for the transition?	Тийм/ Yes	Шилжилтийг тусдаа үнэлгээгээр хийх үед ТҮБ-ын шилжилтийг бататгахад багадаа 0.5 үнэлгээний өдрийг нэмж авч үзнэ.	As a minimum, the assessment shall include an additional 0.5 assessment day to confirm transition of the CAB when the transition is done as a separate assessment.
Бусад/ Others	Тийм/ Yes	<ol style="list-style-type: none"> 1) ИБ нь шилжилтийн үнэлгээний хөтөлбөрт ТҮБ-аас шилжилтийн өргөдөл гаргах хугацааг тодорхойлж болно. 2) ИБ нь шилжилтийн үнэлгээ(үүд)-ийн үр дүнд үндэслэн шилжилтийн шийдвэрийг гаргана. 3) Хэрэв боломжтой бол, ИБ нь ТҮБ-аас ISO/IEC 27001:2022 стандартад нийцсэн чадамжаа харуулсан бол итгэмжлэгдсэн ТҮБ-ын итгэмжлэлийн мэдээлэл (тухайлбал, итгэмжлэлийн гэрчилгээ)-ийг шинэчилнэ. 4) Итгэмжлэгдсэн ТҮБ нь 3-р зүйлд заасан холбогдох хугацаанаас өмнө шилжилтийн үнэлгээг амжилттай хийж чадаагүй бол тус ТҮБ-ын ISO/IEC 27001:2013 стандартын дагуух итгэмжлэлийн хүчинтэй хугацаа нь шилжилтийн хугацаанаас хэтрэхгүй байна. 	<ol style="list-style-type: none"> 1) AB may define the timeline for submitting the transition application by CABs in the transition assessment programme. 2) AB shall make the transition decision based on the result of transition assessment(s). 3) If applicable, AB shall update the accreditation information of the accredited CABs (e.g. accreditation certificate) if their competence for ISO/IEC 27001:2022 has been demonstrated. 4) If the accredited CAB does not successfully complete the transition assessment before the related due date listed in Clause 3, the expiry date of their accreditation for ISO/IEC 27001:2013 shall not be later than the end of the transition period.

4.2 ТҮБ-ын авах арга хэмжээ

4.2 CB Actions

Үйл ажиллагаа/ Activity	Т/Ү Y/N	Тэмдэглэл	Notes
ТҮБ-ын зохицуулалт/ CAB's Arrangements	Тийм/ Yes	<p>1) ТҮБ нь ИБ-ын шилжилтийн зохицуулалт болон энэ баримт бичгийн шаардлагын дагуу ISO/IEC 27001:2022 стандартын шилжилтийн зохицуулалтыг бий болгоно.</p> <p>2) Шилжилтийн зохицуулалт нь ТҮБ болон үйлчлүүлэгч байгууллагын юу хийх талаар тусгасан байна. ТҮБ нь шилжилтийн зохицуулалтын хэд хэдэн баримт бичигтэй байж болно.</p> <p>3) Шилжилтийн зохицуулалт нь дор хаяж дараах зүйлсийг агуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ISO/IEC 27001 стандартын өөрчлөлт, зөрүүний шинжилгээ • Холбогдох баталгаажуулал-тын үйл явц, баримт бичиг, мөн баталгаажуулалтын үйл ажиллагааг удирдах мэдээлэл технологийн системийг өөрчлөх хэрэгцээ • Холбогдох ажилтны ISO/IEC 27001:2022 стандарт болон шилжилтийн үйл явцын талаарх мэдлэг, чадамж • Аудитын баг нь бүхэлдээ ISO/IEC 27002 стандарт дахь бүх мэдээллийн аюулгүй байдлын хяналт, түүний хэрэгжүүлэлтийн талаар мэдлэгтэй байна (ISO/IEC 27006:2015, 7.1.2.1.3 б-г үзнэ үү). • Шилжилтийн үеийн аудитын хөтөлбөр. • Шилжилтийн хөтөлбөр, тухайлбал цаг хугацаа, шилжилтийн аудитын арга барил, үйлчлүүлэгч шилжил-тийн хугацаа дуусахаас өмнө шилжиж чадаагүй тохиолдолд гарах үр дагавар зэрэг шилжилтийн хөтөлбөрийн талаар үйлчлүүлэгчидтэй цаг тухайд нь харилцах харилцаа холбоо 	<p>1) CAB shall establish its transition arrangement for ISO/IEC 27001:2022 considering the requirements of this document and the transition arrangement of the related AB.</p> <p>2) The transition arrangement shall address what the CAB shall do and what the client shall do. The CAB may have several separate documents to address the transition arrangement.</p> <p>3) The transition arrangement shall include at least the consideration of the following:</p> <ul style="list-style-type: none"> • The changes in ISO/IEC 27001 and the gap analysis. • The need to modify the related certification processes, documents and, if applicable, IT systems for managing certification activities. • The relevant personnel are competent for ISO/IEC 27001:2022 and transition process. • The audit team, as a whole, shall have knowledge of all information security controls contained in ISO/IEC 27002:2022 and their implementation (see ISO/IEC 27006:2015, 7.1.2.1.3 b)). • The transition audit programme. • There is a timely communication to the clients on the transition programme, such as the timeline, transition audit approach, and the consequences if the client fails to transition prior to the end of the transition period.

		4) ТҮБ-ууд шаардлагатай арга хэмжээг боломжит хамгийн эрт байдлаар төлөвлөж, эхлүүлэх нь зүйтэй.	4) CABs are encouraged to plan and commence required actions at the earliest opportunity.
Шилжилтийн аудит/ <i>Transition audit</i>	<i>Тийм/ Yes</i>	<p>1) ТҮБ нь шилжилтийн аудитыг магадлах аудит, давтан баталгаажуулалтын аудит болон тусдаа аудитаар дамжуулан явуулж болно.</p> <p>2) Шилжилтийн аудит нь зөвхөн баримт бичгийн үзлэг, ялангуяа технологийн мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг авч үзэхэд тулгуурлахгүй.</p> <p>3) Шилжилтийн аудитад дараах зүйлс орох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ISO/IEC 27001:2022 стандартын зөрүүний шинжилгээ, мөн үйлчлүүлэгчийн МАБМТ-ны өөрчлөлтийн хэрэгцээ • Хэрэглэх тухай мэдэгдэл (SoA)-ийн шинэчлэлт • Хэрэв боломжтой бол, эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний шинэчлэлт • Үйлчлүүлэгч байгууллагын сонгосон шинэ эсхүл өөрчлөгдсөн мэдээллийн аюулгүй байдлын хяналтын үр нөлөө ба хэрэгжилт. <p>4) Хэрэв шилжилтийн аудитын зорилтууд хангагдсан гэж үзвэл ТҮБ нь шилжилтийн аудитыг алсын зайнаас явуулж болно.</p>	<p>1) CAB may conduct the transition audit in conjunction with the surveillance audit, recertification audit or through a separate audit.</p> <p>2) The transition audit shall not only rely on the document review, especially for reviewing the technological information security controls.</p> <p>3) The transition audit shall include, but not be limited to the following:</p> <ul style="list-style-type: none"> • The gap analysis of ISO/IEC 27001:2022, as well as the need for changes to the client's ISMS. • The updating of the statement of applicability (SoA). • If applicable, the updating of the risk treatment plan. • The implementation and effectiveness of the new or changed information security controls chosen by the clients. <p>4) CAB may conduct the transition audit remotely if they ensure the transition audit objectives is met.</p>
Шилжилтийн үед нэмэлт хугацаа хэрэгтэй юу? / <i>Is extra time likely to be needed for the transition?</i>	<i>Тийм/ Yes</i>	<p>1) Шилжилтийн аудитыг давтан баталгаажуулалтын аудиттай хамтад нь явуулж буй тохиолдолд багадаа 0.5 аудитор өдөр байна.</p> <p>2) Шилжилтийн аудитыг магадлан аудиттай хамтад нь явуулж буй тохиолдолд багадаа 1.0 аудитор өдөр байна.</p>	<p>1) Minimum of 0.5 auditor day for the transition audit when it is carried out in conjunction with a recertification audit.</p> <p>2) Minimum of 1.0 auditor day for the transition audit when it is carried out in conjunction with a surveillance audit or as a separate audit.</p>
Бусад/ <i>Others</i>	<i>Тийм/ Yes</i>	<p>1) ТҮБ нь шилжилтийн аудитын хөтөлбөрт баталгаажсан үйлчлүүлэгчээс шилжилтийн өргөдөл гаргах хугацааг тодорхойлж болно.</p> <p>2) ТҮБ нь шилжилтийн аудитын үр дүнд үндэслэн шилжилтийн шийдвэрийг гаргана</p>	<p>1) CAB may define the timeline for submitting the transition application by the certified clients in the transition audit programme.</p> <p>2) CAB shall make the transition decision based on the result of transition audit.</p>

	<p>3) Хэрэв баталгаажсан үйлчлүүлэгчийн МАБМТ нь ISO/IEC 27001:2022 стандартын шаардлагад нийцэж байгаа бол ТҮБ-аас түүний баталгаажуулалтын баримт бичгийг шинэчилнэ.</p> <p>Тайлбар: Үйлчлүүлэгч зөвхөн шилжилтийн аудитад амжилттай хамрагдсанаар баталгаажуулалтын баримт бичгийг шинэчлэх бол түүний одоогийн баталгаажуулалтын мөчлөгийн хүчинтэй хугацаа өөрчлөгдөхгүй.</p> <p>4) Шилжилтийн үеийн төгсгөлд ISO/IEC 27001:2013 стандартад үндэслэсэн бүх баталгаажуулалт цуцлагдах эсхүл хүчингүй болно.</p>	<p>3) CAB shall update the certification documents for the certified client if its ISMS meets the requirements of ISO/IEC 27001:2022.</p> <p>Note: When the certification document is updated because the client successfully completed only the transition audit, the expiration of its current certification cycle will not be changed.</p> <p>4) All certifications based on ISO/IEC 27001:2013 shall expire or be withdrawn at the end of the transition period.</p>
--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

4.3 БУСАД

4.3.1 Шилжилтийн шийдвэрийг дагалдах ТҮБ-ын оффис үнэлгээ нь ТҮБ-ын шилжилтийн зохицуулалт бүрэн хэрэгжиж дуусахаас өмнө шилжилтийн зохицуулалтын хэрэгжилтийн шалгахад чиглэсэн байна. Оффис үнэлгээ нь багадаа дараах зүйлсийг агуулна. Үүнд:

- ТҮБ-ын шинэчилсэн үйл явц, журмын хэрэгжилт
- Холбогдох ажилтны ISO/IEC 27001:2022 стандартын баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцохоос өмнө ур чадвар, чадамжаа харуулсан байдал
- Баталгаажсан үйлчлүүлэгчийн ISO/IEC 27001:2022 стандартын шилжилтийн явц

4.3.2 Шилжилтийн шийдвэрийг дагалдах сонгогдсон бүх гэрчлэх үнэлгээ нь ISO/IEC 27001:2022 стандартад үндэслэсэн байх ба ISO/IEC 27001:2022 стандартын дагуу явуулах тус аудит нь ТҮБ-ын чадамжид чиглэнэ.

ISO/IEC 27001:2022 стандартын шилжилтийн шаардлага ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийн төгсгөл

Нэмэлт мэдээлэл:

Тус баримт бичиг болон ОУИФ-ын бусад баримт бичгийн талаарх нэмэлт мэдээллийг ОУИФ-ын гишүүн, нарийн бичгийн дарга нарын газартай холбогдоно уу.

ОУИФ-ын гишүүдийн талаарх мэдээллийг <http://www.iaf.nu>. цахим хуудаснаас авна уу.

Нарийн бичгийн дарга нарын газар:

ОУИФ-ын нарийн бичгийн дарга
Утас: +1 613 454-8159
И-мейл: secretary@iaf.nu

4.3 OTHER

4.3.1 The CAB office assessment following the transition decision shall focus on the verification of the implementation of the transition arrangement before the CAB's transition arrangement was totally completed. This office assessment shall include the following, at a minimum:

- The implementation of the CAB's revised processes and procedures.
- The competence of the related personnel is demonstrated before they were involved in the ISO/IEC 27001:2022 certification activities.
- The progress of the transition for the certified clients to ISO/IEC 27001:2022.

4.3.2 All witness assessments selected following the transition decision shall be based on ISO/IEC 27001:2022 and focus on the CAB's competence for conducting an audit based on ISO/IEC 27001:2022.

End of IAF Mandatory Document Transition Requirements for ISO/IEC 27001:2022

Further Information:

For further Information on this document or other IAF documents, contact any member of IAF or the IAF Secretariat.

For contact details of members of IAF see the IAF website <http://www.iaf.nu>.

Secretariat:

IAF Corporate Secretary
Telephone: +1 613 454-8159
Email: secretary@iaf.nu